

## ***ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР-III***

### ***Нэг. Ерөнхий мэдээлэл***

#### ***Эрх зүйн үндэслэл.***

1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-д : Хөдөө аж ахуйн салбарын Зорилт 2.-д “Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ”.

2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.48.4-т “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд:

- 2.48-т Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, "Загвар хоршоод"-ыг байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжлэг үзүүлэх

- 2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх,

3. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрт дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- 4.2.4-т Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагаатай уялдуулан сумдад байгуулах;

- 4.2.5-т Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд малчдын оролцох боломжийг нэмэгдүүлэх, малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрт түүхий эд бэлтгэлийн агуулах, тээвэр, тоног төхөөрөмжөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

4. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 4.7.1.хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо нь биржийн байнгын бус оролцогч байхаар заасан.

#### ***Нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал***

Монгол Улсын Засгийн газраас 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Хоршооны тухай хуулийг баталсан бөгөөд үүнээс хойш 1998 онд шинэчлэн найруулж, 2002, 2004, 2005, 2011 онд тус тус 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хоршоо нь өрхийн жижиг бичил бизнесээр хязгаарлагдахгүй, бүс нутаг, тухайн сум, баг, аймаг, дүүргээрээ нэгдэж, хөдөлмөрөөрөө хоршин, хүртэх орлого, ашгаа нэмэгдүүлэх боломж бөгөөд хүн амын ядуурал, ажилгүйдэл, ялангуяа хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг салбар юм.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр улсын хэмжээнд 4377 хоршоо /нийт аж ахуйн нэгжийн 2.8 хувь/ бүртгэлтэй байгаагаас 3693 хоршоо нь аймгуудад 684 нь Улаанбаатар хотод байна.

2018 онд 21 аймагт хийсэн хоршоодын хөгжлийн үнэлгээнд орон нутгийн нийт 3020 хоршоо хамрагдсаны тогтвортой өсөлттэй 239, үйл ажиллагаа нь тогтворжиж буй 580,

идэвхжиж буй 877, идэвхгүй буюу үйл ажиллагаа нь зогсонги 1324 байна. Үнэлгээнд хамрагдаагүй 673 хоршоо нь бүртгэлтэй боловч бодитой оршин тогтнодог эсэх, хоршооны зарчмаар ажилладаг эсэх нь тодорхойгүй байна.

Ангилал	Хоршооны тоо	Эзлэх хувь
Үнэлгээнд хамрагдаагүй	673	18.2
Идэвхгүй буюу зогсонги	1324	35.9
Идэвхжиж байгаа	877	23.7
Үйл ажиллагаа нь тогтворжиж байгаа	580	15.7
Тогтвортой хөгжиж буй	239	6.5
Дүн	3693	100

Тогтвортой ажиллаж буй хоршоодын 9 орчим хувь нь хадгаламж, зээлийн чиглэлээр, 6 нь дундын хоршоо бөгөөд дийлэнх нь гэр бүлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн хоршоог гишүүдийн нийгэм, соёлын хэрэгцээг хангах зорилгоор хоршиж хөдөлмөрлөх биш “хоршоо” гэдэг нэрийг ашиглаж, нэг хүний эрх ашгийн төлөө байгуулах явдал их гарч байна.

Мөн хоршооны удирдлагын менежмент муу гишүүдийнхээ өмнө хүлээх хариуцлага тодорхойгүй, банкнаас зээл авах барьцаа хөрөнгөгүй байх, хоршооны гишүүдийн ажлын үнэлэмж, урамшуулал тогтворжоогүй, бизнесийн төлөвлөлт байхгүйгээс хоршоо бусад бизнесийн хэлбэртэй харьцуулахад өрсөлдөх чадавхи сул, гишүүдийн амьдралд бодит өсөлт, дэвшил гарч хуримтлал үүсэх, шинэ технологи, ноу хау нэвтрүүлэх зэргээр бие даан хөгжиж чадахгүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хоршоодын 8.7 хувь нь огт орлого олоогүй, 54 хувь нь 1 сая төгрөг болон түүнээс бага орлого олсон, 23 орчим хувь нь нэгэн хэвийн орлоготой /орлого нь өсдөггүй/, 20 хувь нь орлого буурсан, 39 хувь нь орлого бага зэрэг өссөн гэсэн дүн гарсан байна.

Ийм учраас хоршооллын хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой нийцүүлэн хоршоог дэмжих түүнчлэн хуульд заасан зорилго, зарчимд нийцсэн хоршоог байгуулах, улсын бүртгэлд бүртгэх, хариуцлага, дотоод хяналтыг нь сайжруулах шаардлагатай байна.

Дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн Хоршооны тухай хуулийг шинэчлэн батлах нь зайлшгүй бөгөөд уг асуудалтай холбогдуулан бусад хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулсан эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

### ***Хоёр. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа.***

**ЗОРИЛГО:** *Хоршооны эрх зүйн орчныг сайжруулж, Засгийн газар, хоршоо, дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэн хоршооны хөгжлийг дэмжих замаар үнэлэмжийг нэмэгдүүлэн Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад хоршоодын үүрэг оролцоог нэмэгдүүлэх*

**Хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлж байгаа болно. Үүнд:**

1. Хоршооны тогтвортой хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх
2. Засгийн газар, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бусад байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн үр дүнг нэмэгдүүлэх
3. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
4. Хоршооны салбарын түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог үүсгэн төлөвшүүлэх
5. Орон нутгийн хөгжилд хоршооны оролцоог тогтвортой нэмэгдүүлэн түүний нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх
6. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэх

## **Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: /2019- 2030он/**

I ҮЕ ШАТ 2019-2024 он

II ҮЕ ШАТ 2025-2030 он

### ***Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.***

#### **1. Хоршооны тогтвортой хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх**

- 1.1. Хоршооны тухай хуулийг боловсронгуй болгож хөгжлийн өнөөгийн түвшинд нийцүүлэх
- 1.2. Хоршооны салбартай холбоотой зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах

#### **2. Засгийн газар, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бусад байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн үр дүнг нэмэгдүүлэх**

- 2.1. Хоршооны хөгжлийн талаарх төр, засгийн бодлогын залгамж чанарыг тогтвортой хадгалж ажиллах,
- 2.2. Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчны чиглэлийн гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдэд хоршоодын оролцоог нэмэгдүүлэх
- 2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.4. Хоршоодод үзүүлэх ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан хоршоодын мэргэжлийн болон үндэсний нэгдсэн холбооны чадавхийг дээшлүүлэх
- 2.5. Хоршоод, тэдний хөгжлийг дэмжигч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, цар хүрээг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах, салбарын мэдээллийн санг баяжуулах, хоршоод хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх

#### **3. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх**

- 3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд улсын төсвийн 2-оос доошгүй хувийг хуваарилж байх
- 3.2. Сумдад хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний парк, бүтээгдэхүүн борлуулалтын зориулалтын төвийг аймаг, орон нутгийн төсөвт тусган барьж байгуулах
- 3.3. Хөдөө аж ахуйн болон жижиг үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн цэгийг аймаг бүрт бий болгон орон нутаг болон хоршоодын захиалгын дагуу нийлүүлж байх тогтолцоог бүрдүүлэх
- 3.4. Хоршооны хөрөнгө өмчлөлийн онцлог байдлыг харгалзсан банкны зээлийн журмыг хөнгөвчлөх асуудлыг судлан шийдвэрлүүлэх
- 3.5. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах
- 3.6. Загвар хоршоодыг байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжих
- 3.7. Орон нутгийн өмчлөлийн ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийг хоршоодод шилжүүлэн дэмжлэг үзүүлэх

#### **4. Хоршооны салбарын түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог үүсгэн төлөвшүүлэх**

- 4.1. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд оролцож буй хоршоодод түүхий эд бэлтгэлийн агуулах, тээвэр ложистик, тоног төхөөрөмжөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- 4.2. Түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх

## **5. Орон нутгийн хөгжилд хоршооны оролцоог тогтвортой нэмэгдүүлэн түүний нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх**

5.1. Хоршоодын хөгжил, чадавхийн байдалд төрөөс үнэлэлт өгч, хариуцлагажуулах

5.2. Хоршооны нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмжийг дээшлүүлэх

5.3. Хоршооны талаарх олон нийтийн эерэг сөрөг сэтгэл зүйн тандалт судалгаа хийж холбогдох арга хэмжээг авах

5.4. Төрийн худалдан авалтанд өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд хоршоод идэвх санаачилгатай оролцох

## **6. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэх**

6.1. Хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх

6.2. Хоршооны гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх

6.3. Хоршоод, холбоодын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх

### ***Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт.***

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хоршооны асуудал эрхэлсэн сайд, Монголын Хоршооллын Үндэсний Нэгдсэн Холбооны тэргүүн нар хариуцан зохион байгуулж, бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийнэ.

### ***Тав. Хөтөлбөрийн санхүүжилт.***

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь эх үүсвэрийг ашиглана:

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Засгийн газрын холбогдох тусгай сангийн хөрөнгө;
- Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөр;
- Банк болон банк бус санхүүгийн байгууллагын эх үүсвэр;
- Бусад эх үүсвэр

### ***Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ***

6.1. Төрийн захиргааны төв байгууллага, Монголын Хоршооллын Үндэсний Нэгдсэн Холбоо энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.